



“Газар шим үйлдвэр” ХК 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан



АЛСЫН ХАРАА

Дэлхийн жишигт хүрнэ.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүнээ дээдлэн эрүүл,
чанартай хүнс үйлдвэрлэгч,
шинийг санаачлагч, тогтвортой
хөгжлийг хэрэгжүүлэгч
компани байна.




ҮНЭТ ЗҮЙЛС

Хүн, Чанар, Хөгжил

2024 оны хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО



2024 оны эхний хагас жилээр цэвэр борлуулалтын орлого 20.8 тэрбум ₮ хүрч өмнөх оны мөн үеэс 20%-ийн өсөлт үзүүлсэн.


ЦЭВЭР АШИГ




2024 оны эхний хагас жилээр цэвэр ашиг 5.03 тэрбум ₮ хүрч өмнөх оны мөн үеэс 20%-ийн өсөлт үзүүлсэн. Энэ нь тайлант онд бүтээгдэхүүний өртгийг бууруулах ажлууд хийгдсэнтэй холбоотой.



НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ



ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ




2024 оны эхний хагас жилээр нийт хөрөнгийн өгөөж 9%, өөрийн хөрөнгийн өгөөж 13% -тэй ажиллаа. Өмнөх оны мөн үеэс нийт хөрөнгийн өгөөж -1% буурсан.

Үүнд: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж нийт хөрөнгийн үнэлгээ өссөн нөлөөлсөн байна. Өөрийн хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үеэс 1%-р өссөн байна.




2024 оны эхний хагас жилээр 9.9 тэрбум ₮ өр төлбөртэй байна. Өмнөх оны мөн үеэс 38% өссөн байна. Нийт өр төлбөрөөс 8.1 тэрбум ₮ нь бакны зээл байна.

ӨР ТӨЛБӨР



НОГДОЛ АШИГ



2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 5.6 тэрбум ₮ буюу нэгж хувьцаанд 4.68₮ ногдол ашигийг хуваарилсан бөгөөд энэ нь тайлант хугацааны ашгийн 86% байсан.

Ногдол ашгийн бодлогоор нийт ашгийн 30%-иас доошгүй хувийг ногдол ашигт хуваарилахыг зорьж байна.



Санхүү байдлын тайлан /хураангуй/

Санхүү байдлын тайлан хураангуй /сая ₮ /	2023 1-р хагас	2024 1-р хагас
Эргэлтийн хөрөнгө	33,001.18	35,558.88
Эргэлтийн бус хөрөнгө	10,860.50	20,912.20
Нийт хөрөнгө	43,861.68	56,471.08
Богино хугацаат өр төлбөр	1,910.27	3,117.16
Урт хугацаат өр төлбөр	5,387.55	6,800.00
Эздийн өмч	36,563.86	46,553.93
Өр төлбөр, эздийн өмч	43,861.68	56,471.09

2024 оны эхний хагас жилийн нийт хөрөнгө 56.4 тэрбум ₮ байна. Өмнөх оны мөн үеэс 12,6 тэрбум ₮ -өөр буюу 29%-р өссөн байна. Нийт хөрөнгийн өсөлтөнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ юм. Дахин үнэлгээгээр үндсэн хөрөнгийн үнэ цэнэ 8,6 тэрбум ₮ -өөр өссөн байна.

Орлого үр дүнгийн тайлан хураангуй/

Орлого үр дүн /сая ₮ /	2023 1-р хагас	2024 1-р хагас
Борлуулалтын орлого /цэвэр/	17,317.89	20,875.24
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	10,085.06	11,751.56
Нийт ашиг	7,232.83	9,123.68
Татварын өмнөх ашиг	4,755.48	5,614.01
Цэвэр ашиг	4,264.88	5,036.44

2024 оны эхний хагас жилийн цэвэр борлуулалт 20.8 тэрбум ₮ байна. Өмнөх оны мөн үеэс 20% цэвэр ашиг мөн 20% өссөн байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан

	Үйл ажиллагаа	Мөнгөн дүн	Зарцуулалт	Зарцуулалтын хувь
Зарцуулалтын төлөвлөгөө	Хүнсний ногооны зоорь барих	5,057,717,514.80	393,025,835	7.77%
	Бүтээгдэхүүн хөгжүүлэлт	2,639,226,407.15	1,630,150,241	61.77%
	Бэлтгэх дамжлагын автоматжуулалт	921,329,945.77	921,913,067	100.06%
	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт	978,913,067.38	1,049,949,659	107.26%
	Нийт дүн	9,597,186,935.10	3,995,038,802	41.63%



2024 оны хагас жилийн маркетинг, борлуулалтын үйл ажиллагаа

Үйлдвэрлэл

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ /ШИРХЭГ/




Нөөшилсэн ногооны үйлдвэрлэл 25,3%,
Артишок ундаа үйлдвэрлэл 41% тус тус өссөн.

Суурилагдсан хүчин чадлын ашиглалт:

Нөөшилсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх оныхоос 4,1% өссөн

Артишок ундаа үйлдвэрлэл дээр 7% буурсан байна.

ХҮЧИН ЧАДЛЫН АШИГЛАЛТ /1 ЭЭЛЖИНД ҮЙЛДВЭРЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН ШИРХЭГЭЭР/




Ногооны зоорины барилгын явц



- Ногооны зoorь - 2400 тонн
- Гүн хөргөлтийн зoorь - 1000 тонн
- Зориулалт - Хүнсний ногоо, жимсний анхан шатны боловсруулалт хийж, жижиглэн болон В2В зах зээлд зориулсан хагас боловсруулсан бүтээгдэхүүн, гүн хөлдөөсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Бүтэц - Оффисын хэсэг, Ажилчдын цайны газар, хувцас солих өрөө, Л абoраoри, 220 мкв талбайтай Нэрийн дэлгүүр, Кафе





Шинэ бүтээгдэхүүн ХӨГЖҮҮЛЭЛТ

- Кетчуп, Халуун ногоотой чихэрлэг Чили соус, Майонез зэрэг бүтээгдэхүүн дээр бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн туршилтыг хийж, түүхий эд болон таг, уутан савлагааны захиалгыг хийн, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд гарахаас өмнөх бэлтгэл ажлуудыг ханган ажиллалаа.
- Хүүхдийн нухаш бүтээгдэхүүний 3 төрөлд үйлдвэрлэлд нэвтрүүлэх туршилтыг хийлээ. Хаяг, шошгоны загварыг эцэслэн батлаж, таг болон 90 гр уутан савлагаа, түүхий эд, тоног төхөөрөөмжийн захиалгыг баталгаажууллаа.



Insight

ЖИМС НОГООНЫ НУХАШНЫ ХУДАЛДАН АВАГЧИЙН ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА

Эхлэл: "Газар шим" ХХК
Гүйцэтгэл: "Грийн Инсайт" ХХК



ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНГЭН БҮТЭЭГДЭХҮҮН ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА


Эхлэл: "Газар шим" ХХК
Гүйцэтгэл: "Грийн Инсайт" ХХК

Ins

Маркетингийн компани ажил

- Хүүхдийн нухаш, кетчуп, майонез бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэн гаргахын өмнө Худалдан авагчийн зан төлөвийн байдлыг харгалзан үзэж түүнд тулгуурлан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргах хэрэгцээ шаардлага тулгарсны дагуу Грийн Инсайт ХХК-иар "Жимс ногооны нухаш, кетчуп, майонез" гурван бүтээгдэхүүний худалдан авагчийн зан төлөвийн судалгаа"-г тус бүр хийлгэн уг судалгаануудыг бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд ашиглан ажиллалаа.
- Артишок брэндийн нэр төрлийг нэмэгдүүлж зах зээл нэвтрүүлэх зорилгоор Эрүүл мэндийн шингэн хүнсний судалгааг хийлгэн түүнд уялдуулан хэрэглэгчийн зан төлөвт тохирсон бүтээгдэхүүн үйлдвэрлэх туршилт, судалгаа, ажиглалтыг ханган ажиллалаа.
- Bsp-bat soluition partners компанитай хамтын ажиллагааны гэрээ байгуулан нөхцөл байдлын шинжилгээ, маркетинг, брэнд хөгжүүлэлт, визуал стратеги хөгжүүлэлт, коммуникаци стратеги хөгжүүлэлт, контент бүтээх гэсэн хэсгүүд үүсгэн мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчилгээ аван маркетингийн үйл ажиллагааг цогцоор нь төлөвлөн гүйцэтгэлээ.
- Аялал зугаалгын улирлыг тохиолдуулан Аялалд амт нэмэх Аяллын багцыг гарган Хот болон хөдөө орон нутагт байршуулалт хийн, борлуулалтыг дэмжих маркетингийн ажлыг хэрэгжүүллээ.

Гайхалтай амтыг Газар шимээс ...



КЕТЧУП ХУДАЛДАН АВАГЧИЙН ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА


Эхлэл: "Газар шим" ХХК
Гүйцэтгэл: "Грийн Инсайт" ХХК

2024 он



НӨӨШИЛСӨН НОГООНЫ БРЭНДИЙН СУДАЛГАА

Эхлэл: "Газар шим" ХХК
Гүйцэтгэл: "Грийн Инсайт" ХХК




ВИЗУАЛ & КОММУНИКАЦ СТРАТЕГИ ХӨГЖҮҮЛЭЛТ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА #13

2024.07.26-ны Баасан гаргаг

bsp


Бүтээгдэхүүний борлуулалт /тоо ширхгээр/






Борлуулалтын онцлох үзүүлэлт

Борлуулалтын тоо ширхэгийн өсөлт




БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТОО ШИРХЭГИЙН ӨӨРЧЛӨЛТ (ХУВИАР)




Харилцагч хамралтын өсөлт

Дүүрэг суваг



Сүлжээ суваг




Нэр төрлийн өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс:

- Борлуулалтын бүсийн хуваарилалт
- Хүрч ажиллаж чадахгүй байгаа худалдааны цэгүүдийг бүрэн хамрах зорилтыг хэрэгжүүлж харилцагч хамралт 41%, харилцагч бүрд хүрч ажиллах борлуулалтын эргэлтийн давтамж 4 дахин өссөн.
- Хөдөө орон нутагт тэлэх бодлого баримталж, гэрээт борлуулагчийг худалдааны төлөөлөгчийн хамт сонгон шалгаруулж, үйл ажиллагаа жигдэрч эхэлсэн.
- Борлуулалтын албаны тээвэр логистикийн хэсгийг бие даасан хэлбэрт шилжүүлэх замаар бүтэц зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг оновчтой болгосон.

2024 оны хагас жилийн үйл ажиллагаа

Хүний нөөцийн бодлого


Орон тооны өсөлт



Бодлого


- Нийт өсөлт – 46,1%
- Ажилтны хуримтлалын хөтөлбөр нийт ажилтны 12,9%-ийг хамруулаад байна.
- Ажилтан хувьцаажуулах хөтөлбөрт 183 ажилтан буюу 73,8%-ийг хамруулаад байна
- Нийт тогтворжилтийн хувьд 90,3%-ийн тогтворжилттой. Ажиллах хүчнээс хамаарах эрсдэл бага
- Тогтворжуулах үүднээс ажилтнаа халамжлах олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Ажилтны дундаж нас




Gen z - 66 буюу 26,6%
 Millenials – 146 буюу 58,8%
 X and Babeboomers – 36 буюу 14,5%

Ажилласан хугацаа




Шинэ ажилтан - 155 буюу 62%
 2-10 жил – 88 буюу 35,4%
 10 жилээс дээш – 22 буюу 14,8%

Хүйсийн харьцаа




Ажиллаж буй чиглэл

- Хангамж, үйлчилгээ
- Нарийн мэргэжил, зөвлөх
- Худалдаа, борлуулалт
- Удирдлага
- Санхүү, бүртгэл
- Үйлвэрлэл, боловсруулалт
- Агуулах, түгээлт
- Маркетинг
- Инженер, техник
- Захиргаа, хүний нөөц



Удирдлагын бүтцийн хувьд

- Гүйцэтгэх түвшин буюу анхан шатны менежер
- Дунд шатны менежерүүд
- Удирдах түвшний менежерүүд





Ажилтан
248



Хэрэглэгч
30,000



Харилцагч
7,040



Бэлтгэн
нийлүүлэгч
519



Хувьцаа
эзэмшигч
3,312

Анхаарал хандуулсанд баярлалаа!